

## НАСАНД ХҮРЭГСДИЙН АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

ЗОХИОГЧ: Jan Basile, MD

ЭМХЭТГЭСЭН: Т.Оюундарь

ОРЧУУЛСАН: Ш. Бүжинлхам, П.Хулан

Эх сурвалжийн сүүлд шинэчлэгдсэн огноо: 2023.01.05

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН: Ш.Бүжинлхам, Ц.Энх-Оюун

Нийтлэгдсэн огноо: 2023.08

### ХУРААНГУЙ

Дэлхий дахинд артерийн гипертензийн (АГ) тархалт АНУ-ын жирэмсэн биш насанд хүрэгсдийн дунд өндөр байдаг бөгөөд эмнэлэгт хандах зонхилох шалтгаан болдог ба байнга жороор эм уух шаардлагатай байдаг [1-3]. Даралт ихсэлт оношлогдсон хүмүүсийн тал нь даралтаа хянаж чаддаггүй. АГ-ийн тархалт, хяналтын талаар өөр сэдэв дээр хэлэлцэнэ. ("Насанд хүрэгсдийн даралт ихсэлтийн тархалт, хяналт" болон "Даралт ихсэлтийн эмчилгээ ба хяналт" -ийг үзнэ үү.)

### НЭР ТОМЬЁО

**Артерийн гипертензи:** АГ ихсэлтийн ангиллыг (хүснэгт 1), Америкийн Зүрх Судасны Коллеж (АЗСК), Америкийн Зүрх Судасны Нийгэмлэгээс (АЗСН) 2017 онд гаргасан [4]. Артерийн гипертензийг оношлохын тулд зөв хэмжиж, үнэлэх шаардлагатай. Даралт хэмжилтийг зөв хийж байгаа эсэхээ доор хүснэгтийн дагуу үнэлнэ. ("Цусны даралтын менежмент" -ийг үзнэ үү.):

- Хэвийн даралт – Агшилтын даралт буюу Систолын даралт (СД) <120 ммМУБ, сулралтын даралт буюу Диастолын даралт (ДД) <80 ммМУБ
- Даралт ихсэлт – СД 120 - 129 ммМУБ, ДД <80 ммМУБ
- Артерийн гипертензи :
  - 1 зэрэг – СД 130 - 139 ммМУБ эсвэл ДД 80 - 89 ммМУБ
  - 2 зэрэг – СД дор хаяж 140 ммМУБ-аас, эсвэл ДД 90 ммМУБ-аас дээш байх

Мөн Даралт ихсэлтийг зэргээр ангилахад эргэлзээтэй байвал дээрх үе шатны аль илүү өндрөөр нь авна.

Зөвхөн СД ихсэлт гэдэг нь  $\geq 130$  ммМуБ, ДД <80 ммМуБ байх бол, зөвхөн сулралын даралт ихсэлт гэдэг нь СД <130 ммМуБ ДД  $\geq 80$  ммМуБ байхыг хэлнэ. Харин СД  $\geq 130$  ммМуБ, ДД  $\geq 80$  ммМуБ байхыг холимог даралт ихсэлт гэнэ.

Европын Зүрх Судасны Нийгэмлэг (ЕЗСН) болон Европын Гипертензийн Нийгэмлэг (ЕГН), Олон Улсын Даралт Ихсэлтийн Нийгэмлэг, Үндэсний Эрүүл мэнд, Сувилахуйн Хүрээлэнгийн

удирдамжаар СД  $\geq 140$  ммМУБ эсвэл ДД  $\geq 90$  ммМУБ-аас дээш байхыг даралт ихсэлт гэж тодорхойлдог (хүснэгт 2) [5-7].

Даралт ихсэлтийн тодорхойлолт нь цусны даралт болон зүрх судасны өвчний эрсдэлийн тохиолдлыг хүн амд төрөл бүрийн тоног төхөөрөмж дээр хэмжилт хийн харьцуулан судалсны үндсэнд тогтоосон[8]. ('Даралт ихсэлтийн хүндрэл' сэдвийг харна уу.)

Даралт ихсэлтийг оношлоход давтан хэмжилтүүдийн үр дүнг харьцуулан оношийг тавьдаг. Даралт ихсэлтийн оношилгоог доорх алгоритмын дагуу хийнэ (алгоритм 1, хүснэгт 3). ("Даралт ихсэлтийг оношлох нь" -ийг үзнэ үү.)

**Эмнэлгийн болон гэрийн даралтын хэмжилтийг үнэлэх:** Даралт ихсэлтийг эмнэлэгт болон гэрт хэмжсэн даралтыг харьцуулан оношилно. АЗСК, АЗСН-ийн 2017 оны удирдамжаар доор бичигдсэн даралт нэгээс дээш удаа хэмжигдсэн тохиолдолд АГ гэж баталгаажуулан оношилно. ("АГ оношлох нь" -ийг үзнэ үү.)

Насанд хүрэгсдийн даралтыг 24 цагийн даралтын монитор, гэрт хянах нь сэдвийн талаар ("Эмнэлгээс гадна даралт хэмжих нь: Эмнэлэгт болон өөрөө хэмжиж даралтаа хянах нь" болон "Насанд хүрэгсдийн даралт ихсэлтийг хэмжиж, оношлох, хянах" сэдвийн 'Эмнэлэгт даралт хянах' -ийг үзнэ үү.)

Доорх шалгууруудаас дор хаяж нэг шалгуур хангавал 24 цагийн даралтын монитор ашиглан даралт ихсэлтийн оношийг баталгаажуулна (хүснэгт 3) [4].

- 24 цагийн дундаж СД  $\geq 125$  ммМУБ ДД  $\geq 75$  ммМУБ
- Өдрийн дундаж СД  $\geq 130$  ммМУБ эсвэл ДД  $\geq 80$  ммМУБ (Хамгийн тохиромжтой оношилгооны шалгуур)
- Шөнийн дундаж СД  $\geq 110$  ммМУБ эсвэл ДД  $\geq 65$  ммМУБ

ЕЗСН болон ЕГН, Олон Улсын Даралт Ихсэлтийн Нийгэмлэг, Үндэсний Эрүүл мэнд, Сувилахуйн Хүрээлэнгийн удирдамжид 24 цагийн дундаж СД  $\geq 130$  ммМУБ эсвэл ДД  $\geq 80$  ммМУБ, өдрийн цагийн дундаж СД  $\geq 135$  ммМУБ эсвэл ДД  $\geq 85$  ммМУБ бол артерийн гипертензи гэж оношилно (хүснэгт 2) [5-7].

Эмнэлэгт хэмжсэн артерийн даралтыг гэрт хэмжигдсэн даралттай харьцуулах нь Цагаан халаадны даралт ихсэлт, далд даралт ихсэлтээс ялган оношлоход хэрэгтэй байдаг.

**Цагаан халаадны даралт ихсэлт:** Эмнэлэгт хэмжсэн артерийн даралт нь гэрт хэмжсэн даралтаас илүү өндөр байх, оношилгооны шалгуурт таарахгүй зөрөх (хүснэгт 4). ("Цагаан халаадны болон далд даралт ихсэлт" болон "Эмнэлгээс гадна даралт хэмжих нь: Эмнэлэгт болон өөрөө хэмжиж даралтаа хянах нь" -ийг үзнэ үү.)

**Далд даралт ихсэлт:** Гэрт хэмжигдсэн артерийн даралт тогтмол өндөр байсан ч эмнэлэгт хэмжсэн артерийн даралт бага байж оношилгооны шалгуурт таарахгүй байх ("Цагаан халаадны болон далд даралт ихсэлт" болон "Эмнэлгээс гадна даралт хэмжих нь: Эмнэлэгт болон өөрөө хэмжиж даралтаа хянах нь" -ийг үзнэ үү.)

### ЦУСНЫ ДАРАЛТ ХЭМЖИЛТ

Тохиромжтой, стандарт аргаар цусны даралт хэмжих нь чухал [9,10]. 24 цагаар даралт хянах, гэрт болон эмнэлэгт даралт хэмжих сэдвүүдийг цааш дэлгэрүүлэн харна уу. ("Эмнэлгээс гадна даралт хэмжих нь: Эмнэлэгт болон өөрөө хэмжиж даралтаа хянах нь" болон "Насанд хүрэгсдийн даралт ихсэлтийг хэмжиж, оношлох, хянах" -ийг үзнэ үү.)

**Эмнэлэгт суурилсан даралт хэмжилт:** Үнэн зөв хэмжилт хийхийн тулд зөв үйлдлийн дарааллыг мөрдөх хэрэгтэй (хүснэгт 1) [5,9-11]. Тохиромжтой хэмжээтэй манжет сонгон хэрэглэх хэрэгтэй (хүснэгт 5). ("Насанд хүрэгсдийн даралт ихсэлтийг хэмжиж, оношлох, хянах" -ийг үзнэ үү.)

Чагнууртай даралтын аппаратаас илүү чагнуургүй автомат даралтын аппарат хэрэглэх нь тохиромжтой [12]. ("Насанд хүрэгсдийн даралт ихсэлтийг хэмжиж, оношлох, хянах" сэдвийн 'Автомат даралтын аппаратаар эмнэлэгт хэмжих нь' -ийг үзнэ үү.)

Автомат даралтын аппарат нь өвчтөн сууж, тайван байх дараалсан хэмжилтийг хийхэд тохиромжтой өдрийн цагийн даралтыг хэмжихэд уламжлалт даралтын аппаратаас илүү тохиромжтой байдаг мөн цагаан халаадны нөлөөг багасгадаг. Хэрэв автомат аппарат байхгүй бол өвчтөнийг 5 минутаас багагүй тайван, зөв суулгаж 2-оос доошгүй удаа хэмжих шаардлагатай (хүснэгт 1). Олон удаагийн хэмжилтэд 2 гарт хэмжих хэрэгтэй. Настай хүмүүст, ортостатик шинж тэмдэг байгаа тохиолдолд байрлалаас хамаарсан хэмжилт хийх хэрэгтэй.

- СД баруун зүүн гарт бараг адил байна. 2 гарт хэмжсэн даралтын зөрүү 15 ммМуб-аас дээш байвал захын судасны артерийн судасны өвчин, эгмийн доорх судасны нарийсал байж болзошгүй. 2 гарт хэмжсэн даралтын ялгаа илт их байвал, дараа дараагийн үзлэгт аль өндөр 2-ыг ашиглахаар тэмдэглэнэ. ("Насанд хүрэгсдийн даралт ихсэлтийн оношилгоо, менежментийн цусны даралт хэмжих" -ийг үзнэ үү.)
- Настай хүн эсвэл байрлалын гипотензи: СД баруун болон зүүн гарт их ялгаатай байх ба даралтын аль өндөр 2 хэмжилтийн утгыг авна. Байрлалын гипотензи гэдэг нь чихрийн шижин, паркинсоны өвчтэй хүнд хэвтээ байрлалаас босоо байрлалд ороход толгой эргэдэг эсвэл босоход бие сулардаг шинж тэмдгүүдтэй 65-аас дээш настай

хүнд СД 20 ммМУБ эсвэл түүнээс дээш хэмжээгээр багасах ("Ортостатик гипотензийн эмгэг жам, шалтгаан, үнэлгээ" -г үзнэ үү.)

**24 цагийн даралт хэмжилт (Алтан стандарт):** 24 цагийн монитор нь өдрийн цагт 15-20 минут тутамд, шөнө 30-60 минут тутамд даралтыг хэмждэг ба АГ оношийг батлах, цагаан халаадны даралт ихсэлт, далд даралт ихсэлтийг ялган оношлох найдвартай арга боловч тэр бүр хийх боломжгүй байдаг (хүснэгт 3) [13]. 24 цагийн монитороор бай эрхтний гэмтэл, зүрх судасны эрсдэлт тохиолдлыг таамаглах боломжтой. Энэ аргаар ганцхан шөнийн даралтыг хэмжих боломжтой. ("Эмнэлгээс гадна даралт хэмжих нь: Эмнэлэгт болон өөрөө хэмжиж даралтаа хянах нь" хэсгийг үзнэ үү.)

Дараах тохиолдлуудад 24 цагийн монитор ашиглах нь тохиромжтой байдаг:

- Үечилсэн даралт ихсэлтийн сэжигтэй (жишээ нь феохромоцитома)
- Цагаан халаадны нөлөөтэй нь тогтоогдсон өвчтөнд эмийн нөлөөллийг үнэлэх
- Даралт бууруулах эм хэрэглэх үеийн даралт буурах шинж тэмдэг
- Тэсвэртэй даралт ихсэлт
- Автоном мэдрэлийн эмгэг
- Далд даралт ихсэлтийн сэжигтэй

**Гэртээ даралтаа хянах:** Өвчтөн тохиромжтой даралтын аппарат, зөв техникээр гэртээ даралтаа хэмжиж хянах хэрэгтэй. Өвчтөн автомат даралтын аппаратаар бугалгадаа хэмжилт хийхдээ, чимээ багатай өрөөнд 5 минут тайван сууж, нуруу, гараа тулгууртай байрлуулна, хөлөө зөрүүлж солбиогүй байрлуулна. Өглөө, орой бүрд сар бүр долоо хоногт хэмжин дор хаяж 12-14 удаа даралтаа хэмжинэ. Бүх хэмжилтийн дунджаар эмнэлзүйн оношилгооны шийдвэр гарна (хүснэгт 6). Гэрийн даралтын хяналтаар өвчтөн даралтаа хянаж байгаа эсэхийг мөн үнэлнэ. Өвчтөнд даралтаа гэртээ хянах заавар, зөвлөгөөг сайтар өгөх хэрэгтэй. ('Даралт ихсэлтийг оношлох нь' -ийг үзнэ үү.)

## АНХДАГЧ ГИПЕРТЕНЗИ

**Эмгэг жам:** Цусны даралт нь зүрхний шахалт, судасны эсэргүүцлээс үүсдэг бөгөөд цусны даралт орчны нөлөөнөөс хамгаалан эд эрхтний цусан хангамжийг тогтмол байлгахаар хэлбэлзэж байдаг.

Цусны даралт (АД) = Зүрхний гаралт (СО) х Системийн судасны эсэргүүцэл (SVR)

Гол хүчин зүйл нь симпатик мэдрэлийн тогтолцоо, ренин- ангиотензин- альдостероны тогтолцоо, сийвэнгийн эзлэхүүн гурав юм. Анхдагч даралт ихсэлтийн эмгэг жам тодорхой

биш ч удамшлын, хүрээлэн буй орчны нөлөөнөөс зүрх судас, бөөрний бүтэц үйл ажиллагаанд өөрчлөлт гарснаас үүсэх нь түгээмэл байдаг.

### Эрсдэлт хүчин зүйлс:

- Насжилт – Нас нэмэгдэх нь цусны даралт ихсэх ялангуяа СД ихсэлтийг нэмэгдүүлдэг.
- Таргалалт – Жин нэмэгдэх, таргалалттай болох нь гол эрсдэлт хүчин зүйл болдог. [16,17] ("Даралт ихсэлтийн үед илүүдэл жин, таргалалттай хүний жинг бууруулах нь" -ийг үзнэ үү.)
- Удамшлын түүх – Эцэг эхийн хэн нэг нь эсвэл 2-уул даралт ихэсдэг бол 2 дахин эрсдэлтэй байдаг. Генетикийн хүчин зүйл 30% нөлөөтэй байдаг [18,19]. ("Даралт ихсэлтийн эмгэг жамд удамшлын нөлөө" сэдвээс үзнэ үү.)
- Яс үндэс – Хар арьстнуудад хүнд хэлбэрийн даралт ихсэлт залуу наснаас ихсэх магадлал илүү өндөр байдаг. ("Хар арьстны дундах даралт ихсэлтийн тархалт" сэдвээс үзнэ үү.)
- Нефроны тоо бууралт – Насанд хүрэгсдийн нефроны тоо цөөн байх нь генетикийн хүчин зүйлс, ургийн хөгжлийн явцад хүчил төрөгчийн дутагдалтай байх, эмийн бодисын хэрэглээ, хоол тэжээлийн дутагдалтай байсан зэргээс шалтгаалан, мөн дутуу төрөлт, төрсний дараа хоол тэжээлийн дутагдалтай байх, халдварт өртөх зэрэг шалтгаанаас үүснэ. ("Анхдагч даралт ихсэлтийн улмаас жин багатай төрөх эмгэг жам" сэдвээс үзнэ үү.)
- Давсны хэрэглээ өндөр байх – Өдөрт 3 гр-аас илүү давс хэргэлдэг байх ("Анхдагч даралт ихсэлтийн үед давсны хэрэглээ, давс хязгаарлах" сэдвээс үзнэ үү.)
- Архи согтууруулах ундааны хэтрүүлсэн хэрэглээтэй байх ("Архины даамжирсан хэрэглээний үе дэх зүрх судасны өвчний ач холбогдол, эрсдэлт хүчин зүйл" сэдвийн 'Даралт ихсэлт' сэдвээс үзнэ үү.)
- Хөдөлгөөний дутагдал [16,20]. ("Дасгал хөдөлгөөнөөр даралт ихсэлтээс сэргийлэх эмчлэх нь" сэдвээс үзнэ үү.)
- Дутуу нойртой байх – Өдөрт 7 цагаас бага унтдаг байх нь гипертензийн эрсдэлийг нэмэгдүүлдэг [21-23], [24,25]. ("Дутуу нойр: Тодорхойлолт, тархалт, сөрөг үр дагавар" сэдвээс үзнэ үү.)
- Нийгмийн хүчин зүйлс – Нийгэм эдийн засгийн байдал дорой байх, хоол хүнс, орон байр баталгаатай биш байх зэрэг. ("Хар арьстны дундах даралт ихсэлтийн тархалт" сэдвээс үзнэ үү.)

## ГИПЕРТЕНЗИД НӨЛӨӨЛӨХ ХОЁРДОГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

Олон эрүүл мэндийн нөхцөл байдлуудын улмаас хоёрдогч даралт ихсэлт болдог. Олон тохиолдолд анхдагч гипертензийн эрсдэлт хүчин зүйлстэй байх, даралт хянахад саад бэрхшээлтэй байдаг. ("Хоёрдогч гипертензийг үнэлэх" болон "Тэсвэртэй гипертензийн тодорхойлолт, эрсдэлт хүчин зүйл, үнэлэх нь", сэдвийн 'Гипертензийн хоёрдогч шалтгаан' сэдвээс үзнэ үү.)

- Эмийн хэрэглээ [4,5]:
  - Жирэмснээс хамгаалах дааврын бэлдмэл ("Жирэмснээс хамгаалах: Дааврын жирэмснээс хамгаалах арга ба цусны даралт" сэдвээс үзнэ үү.)
  - Стероид бус үрэвслийн эсрэг эм ("Стероид бус үрэвслийн эсрэг эм, ацетаминофен: Цусны даралт, даралт ихсэлтэд нөлөөлөх нь" сэдвээс үзнэ үү.)
  - Сэтгэл гутралын эм, сэтгэц нөлөөт эм
  - Стероид дааврын эмүүд
  - Хамрын цацлага фенилэфрин, псевдоефедрин
  - Жин хасах бэлдмэлүүд
  - Натрийн агууламжтай ходоодны хүчил бууруулах бэлдмэлүүд
  - Эритропоэтин
  - Циклоспорин, такролимус
  - Мансууруулах бодисууд
- Анхдагч бөөрний өвчин – цочмог болон архаг бөөрний өвчний үед даралт ихсэх боломжтой ("Бөөрний цочмог болон архаг өвчний үеийн даралт ихсэлтийн тойм" сэдвээс үзнэ үү.)
- Анхдагч алдостеронизм – минералкортикоид хэрэглэж байгаа өвчтөнд тун хэтэрснээс даралт ихсэлт, цусан дах кали багасах, бодисын солилцооны шүлтшилт гурвал илэрнэ. Гэхдээ 50-70%-д нь кали хэвийн байж болно ("Анхдагч алдостеронизмын эмнэлзүй, эмгэг жам" ба "Анхдагч алдостеронизмын оношилгоо" ба "Минералкортикоидын илүүдлийн хам шинж" сэдвээс үзнэ үү.)
- Бөөрний судасны шалтгаант даралт ихсэлт ("Бөөрний судасны шалтгаант даралт ихсэлтийг оношлох нь" сэдвээс үзнэ үү.)
- Нойрон дунд амьсгал тасалдах хамшинж – Даралт ихсэлтэд хүргэдэг бие даасан хүчин зүйл. ("Насанд хүрэгсдийн нойрон дунд амьсгал тасалдах эмгэг ба зүрх судасны өвчин" сэдвээс үзнэ үү.)

- Кушингийн хам шинж – даралт ихсэлтийн ховор шалтгаан болох боловч, кушингийн хам шинжтэй өвчтөний нас баралтын гол шалтгаан болдог. ("Кушингийн өвчний эмнэлзүйн илрэл" сэдвээс үзнэ үү.)
- Бусад дотоод шүүрлийн эмгэгүүд – бамбайн дааврын дутагдал болон хордлого, гиперпаратиройдизм нь даралт ихсэлтэд хүргэнэ ("Гипотиройдизм зүрх судасны өвчинд нөлөөлөх нь" ба "Гипертиройдизм зүрх судасны өвчинд нөлөөлөх нь" ба "Анхдагч гиперпаратиройдизм: Эмнэлзүйн илрэл" сэдвийн 'Зүрх судас' сэдвээс үзнэ үү.)
- Гол судасны нарийсал – залуучуудын даралт ихсэлтийн гол шалтгаан болдог [28]. ("Гол судасны нарийслын эмнэлзүй, оношилгоо" сэдвээс үзнэ үү.)

## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИЙН ХҮНДРЭЛ

АГ нь зүрх судас, бөөрний өвчний хүндрэл үүсгэдэг ("АГ зүрх судасны эрсдэл" сэдвээс үзнэ үү). Үүнд:

- Зүрхний зүүн ховдлын томрол (зураг 1) [29,30]
- Зүрхний дутагдал, зүрхний шахалтын фракц (агшилтын), нөөц шахалтын фракц (сулралтын) [31]. ("Зүрхний дутагдлын тархалт" сэдвээс үзнэ үү.)
- Зүрхний цус хомсдох өвчин, миокардын инфаркт, титэм судасны эмгэг [32,33] ("Харвалтын оношилгоо", сэдвийн 'Экологи, эрсдэлт хүчин зүйл' сэдвээс үзнэ үү.)
- Тархины цус харвалт [32,34] ("Тархины цус харвалт: Эмгэг жам, эмнэлзүй, оношилгоо" сэдвээс үзнэ үү.)
- Зүрхний ишеми өвчин зүрхний булчингийн инфаркт, титэм судасны ажилбар орно. [32,35] ("Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлийн тойм" сэдвээс үзнэ үү.)
- Бөөрний архаг өвчин, бөөрний өвчний эцсийн шат [36,37] ("Даралт ихсэлттэй нефросклерозын эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ" ба "Насанд хүрэгсдийн чихрийн бус шижингийн бөөрний архаг өвчний үеийн даамжрал болон даралт ихсэлтийн эмчилгээ" сэдвээс үзнэ үү.)

АГ нь тамхи таталт, дислипидеми, чихрийн шижингээс илүү цаг бусаар зүрх судасны өвчнөөр нас барах хянаж болох эрсдэлт хүчин зүйл байдаг [35]. Даралт ихсэлт нь голдуу таргалалт, эрүүл бус хооллолт, хөдөлгөөний дутагдалтай хамт байдаг. Даралт ихсэлт болон бусад эрсдэлт хүчин зүйл өвчтөнд байх нь гэнэтийн зүрх судасны өвчнөөр нас барах эрсдэлийг нэмэгдүүлж байдаг [4]. СД 20 ммМУБ, ДД 10 ммМУБ-аар илүү байх нь зүрхний өвчин, харвалтаар нас барах эрсдэлийг 2 дахин ихэсгэдэг.



СД 120 - 129 ммМУБ, ДД 80 - 84 ммМУБ байх нь зүрх судасны шалтгаант тохиолдлын эрсдэлийг 1.1 - 1.5 дахин, СД 130 - 139 ммМУБ, ДД 85 - 89 ммМУБ байх нь 1.5 - 2.0 дахин ихэсгэдэг. Уг хамаарал нь хүйс, яс үндэст адил байсан бол насжилтад ялгаатай байсан. 50-60 насанд СД өндөр байх нь илүү эрсдэлтэй, 50-аас доош насанд ДД өндөр байх нь илүү эрсдэл өндөртэй нь батлагдсан [38,39]. ДД <130 ммМУБ байх, СД салангид өндөр байх нь нас хамаарахгүй, зүрх судасны өвчний эрсдэлийг таамаглахгүй [40].

## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИЙН ОНОШИЛГОО

Бие даасан өвчтөнд АГ-ийн оношийг тогтоохын тулд цусны даралтыг олон удаа хэмжих, зохих арга техникийг ашиглах, мөн ердийн оффисын нөхцөл байдлаас гадуур хийсэн хэмжилтийг ашиглах шаардлагатай.

**Эрт илрүүлэг:** 18-аас дээш настай хүмүүст жил бүр даралтыг хэмжиж эрт илрүүлэг хийж байх нь тохиромжтой. АГ эрсдэлт хүчин зүйл болох таргалалт, өмнө нь СД 120 ммМУБ-аас дээш хэмжигдэж байсан хүмүүст хагас жил тутамд эрт илрүүлэг хийж даралтын хэмжээг шалгаж байх хэрэгтэй [4,5,42].

**Оношилгоо:** Дараах тохиолдлуудад нэмэлт хэмжилт хийхгүйгээр онош тавьж болно.

- СД  $\geq 180$  ммМУБ эсвэл ДД  $\geq 120$  ммМУБ хүрэх ("Насанд хүрэгсдийн хүнд хэлбэрийн шинж тэмдэггүй даралт ихсэлтийн менежмент" ба "Насанд хүрэгсдийн даралт ихсэлтийн аюултай байдлын үнэлгээ, эмчилгээ" сэдвээс үзнэ үү.)
- СД  $\geq 160$  ммМУБ эсвэл ДД  $\geq 100$  ммМУБ бөгөөд зүрхний зүүн ховдлын томрол, нүдний торлогийн гэмтэл, зүрх судасны цус хомсдох зэрэг өвчнүүдтэй хавсарсан нөхцөл байж болно.

Бусад өвчтөнүүдэд насанд хүрэгсдийн АГ оношлох алгоритмын дагуу оношилгоог хийнэ. Ихэнх тохиолдолд үйлчлүүлэгчийн гэртээ хэмжсэн хэмжилтийг оношилгоонд эхлээд ашиглана. [14,15,45]

- Гэрт хэмжсэн даралт эмнэлэгт хэмжсэн даралттай таарч СД  $\geq 130$  ммМУБ эсвэл ДД  $\geq 80$  ммМУБ байгаа тохиолдолд АГ гэж оношилно
- Гэрт хэмжсэн даралт, эмнэлэгт хэмжсэн даралттай зөрүү ихтэй байгаа тохиолдолд 24 цагийн монитороор хянаж өдрийн дундаж СД  $\geq 130$  ммМУБ эсвэл ДД  $\geq 80$  ммМУБ байгаа тохиолдолд даралт ихсэлт гэж оношилно.
- Гэртээ даралтаа хэмжих боломжгүй өвчтөнд эмнэлэгт дор хаяж 3 удаа долоо хоногоос 1 сарын зайтай ирж даралтаа хэмжүүлэн дундаж СД  $\geq 130$  ммМУБ эсвэл ДД  $\geq 80$  ммМУБ байгаа тохиолдолд АГ гэж оношилно

Эмнэлэгт хэмжсэн СД  $\geq 130$  ммМУБ, ДД  $\geq 80$  ммМУБ боловч гэртээ хэмжсэн СД  $< 130$  ммМУБ, ДД  $< 80$  ммМУБ байвал цагаан халаадны даралт ихсэлт байх магадлалтай. Ийм тохиолдолд



24 цагийн монитор ашиглан оношлох нь тохиромжтой. Цагаан халаадны даралт ихсэлт байгаа тохиолдолд даралт ихсэлттэй болох эрсдэлтэй гэж үзэн гэртээ даралтаа жил хэмжиж байхыг зөвлөнө.

Эмнэлэгт хэмжсэн СД 120 - 129 ммМУБ эсвэл ДД 75 - 79 ммМУБ байгаа зүрх судас, бөөрний өвчтэй, зүрх судасны өвчний эрсдэл өндөртэй өвчтөн мөн гэрээр даралтаа хянаж байх шаардлагатай. Эмнэлэгт хэмжсэн СД <130 ммМУБ эсвэл ДД <80 ммМУБ байгаа боловч гэрт хэмжигдсэн СД  $\geq 130$  ммМУБ эсвэл ДД  $\geq 80$  ммМУБ байвал далд даралт ихсэлт байж болзошгүй. Далд даралт ихсэлтийг АГ гэж үзэн эмчилгээг эхлүүлнэ.

## ҮНЭЛГЭЭ

Даралт ихсэлт гэрийн болон эмнэлгийн хэмжилтээр батлагдсан тохиолдолд дараах нөхцөл байдлуудыг үнэлнэ ("**Насанд хүрэгсдийн даралт ихсэлтийн эхний үнэлгээ** сэдвээс үзнэ үү.):

- Бай эрхтний гэмтэл
- Бөөр, зүрх судасны өвчтэй
- Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлтэй, эсвэл эрсдэлгүй ("Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлийн тойм" сэдвээс харна уу.):
- Амьдралын хэвшил даралт ихсэхэд гол нөлөөтэй
- Нөлөөлөх стероид бус үрэвслийн эсрэг эм, жирэмснээс хамгаалах эм хэргэлдэг

**Өвчний түүх:** Амьдралын түүхээс дараах эрсдэлт хүчин зүйлсийг тодруулах шаардлагатай ('Анхдагч АГ эрсдэлт хүчин зүйл' сэдвээс үзнэ үү.) Үүнд: Артерийн гипертензи оношлогдсон хугацаа, даралт буулгах эмийн хэрэглээ, даралтад нөлөөлж болзошгүй эмийн хэрэглээ, удамшлын өгүүлэмж, артерийн гипертензийн хоёрдогч шалтгаан зэрэг орно.

**Бодит үзлэг:** Бай эрхтний гэмтэл илэрсэн эсэхийг үнэлж, хоёрдогч даралт ихсэлтийн шалтгаан, зүрх судасны бусад өвчин байгаа эсэхийг шалгана. Үзлэгт даралт ихсэлтээс шалтгаалсан торлогийн эмгэг байгаа эсэхийг шалгана (хүснэгт 8).

**Лабораторийн шинжилгээ:** Шинээр оношлогдсон АГ-тэй хүмүүст дараах шинжилгээг хийнэ. [4,46,47] ("**Насанд хүрэгсдийн АГ-ийн эхний үнэлгээ**", сэдвийн 'Лабораторийн оношилгоо' сэдвээс үзнэ үү.)

- Электролит, кальци, ийлдэсний креатинин, тТШХ
- Өлөн үеийн сахар
- Шээсний шинжилгээ
- Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
- Бамбай булчирхайн идэвхжүүлэгч даавар

- Өөх тосны фракц
- Зүрхний цахилгаан бичлэг
- 10 жилийн судасны хатуурлын эрсдэлийг тооцоолох

#### Нэмэлт шинжилгээнүүд:

- Шээсний альбумин креатинины харьцаа: Альбумин шээсээр их ялгарах нь зүрх судасны өвчний биеэ даасан эрсдэлт хүчин зүйл юм. Чихрийн шижин, бөөрний архаг өвчтэй хүн бүрд шээсээр албумин ялгарч байгаа эсэхийг үзэх шаардлагатай [48]. ("Зүрх судасны өвчин ба шээсээр альбумин ихээр ялгарах" ба "Бөөрний архаг өвчний тархалт" сэдвээс үзнэ үү.)
- Зүрхний хэт авиан шинжилгээгээр зүрхний зүүн ховдлын томролыг үнэлнэ [49].

**Хоёрдогч АГ-ийг үнэлэх:** Хоёрдогч АГ-ийн шалтгаан тодорхой бус боловч шинжилгээ хийж илрүүлэхэд төвөгтэй байдаг тул бүх хүнд шинжилгээ хийхийг зөвлөхгүй. Харин гэнэт хэвийн бус байдлаар даралт өндөр болох, эмд тэсвэртэй даралт ихсэлт, ийлдсэнд кали багасах, хэвлийд эмгэг судасны шуугиан сонсогдох зэрэг шинж тэмдэг илэрсэн тохиолдлуудад шинжилгээ хийж онош тодруулах хэрэгтэй. ("Хоёрдогч даралт ихсэлтийн үнэлгээ" сэдвээс үзнэ үү.)

#### ЭМЧИЛГЭЭ

Даралт ихсэлт оношлогдсон хүн бүрд эмийн эмчилгээ шаардлагагүй байдаг, харин амьдралын хэв маяг өөрчлөх зөвлөгөөг бүх өвчтөнд өгнө.

**Эмийн бус эмчилгээ:** Амьдралын хэв маяг өөрчлөх зөвлөгөөнөөс хяналтын үзлэгт ирэх бүрд дор хаяж нэгийг нь зөвлөнө (хүснэгт 9) [4,5,50].

- Давсны хэрэглээг бууруулах – Давсны хэрэглээг бууруулснаар артерийн гипертонитэй хүний даралт 4.8/2.5, хэвийн даралт 1.9/1.1 ммМУБ-аар буурдаг. Даралтаас гадна зүрх судасны өвчин, нас баралтад мөн давсны хэрэглээ нөлөөлдөг (зураг 4) [51,52]. ("Анхдагч даралт ихсэлтийн үед давсны хэрэглээ, хэрэглээг бууруулах" сэдвээс үзнэ үү.)
- Калийн ялгарлыг бууруулах эм хэрэглэсэн эсвэл бөөрний архаг өвчтэй хүнээс бусад тохиолдолд хоол хүнсээр авах калийн хэмжээг нэмэгдүүлнэ [4]. ("Даралт ихсэлт ба кали" сэдвээс үзнэ үү.)
- Жин хасах – Илүүдэл жинтэй, таргалалттай хүн 1 кг жин хасах бүрд даралт 0.5-2 ммМУБ-аар буурдаг [53, 54, 55] (Зураг 5) ("Даралт ихсэлтээс хоолны дэглэмээр эмчлэх, урьдчилан сэргийлэх нь" ба "Даралт ихсэлтийн үед жингийн илүүдэл, таргалалт, жин бууруулах" сэдвээс үзнэ үү.)

- Даралт бууруулах хоолны дэглэм – Жимс ногоо, тослог багатай сүү сүүн бүтээгдэхүүн хэрэглэх, бүхэл үр тариа, загас, самар, чихэр, амт оруулагч багатай ундаа, улаан мах түлхүү хэрэглэнэ. Ингэснээр кали, магни, кальци, уураг, эслэг их хүнсээр авч ханасан өөх тос, холестерин бага хэрэглэгдэнэ. ("Даралт ихсэлтээс хоолны дэглэмээр эмчлэх, урьдчилан сэргийлэх нь" сэдвээс үзнэ үү.)
- Дасгал, хөдөлгөөн – Аэробик, динамик болон изометрик эсэргүүцэлтэй дасгал тогтмол хийснээр СД 4 - 6 ммМУБ, ДД 3 ммМУБ- аар буурна. ("Дасгал хөдөлгөөнөөр даралт ихсэлтээс сэргийлэх эмчлэх нь" сэдвээс үзнэ үү.)
- Архины хэрэглээг хязгаарлах – Эмэгтэй хүн өдөрт 2 буюу түүнээс дээш стандарт хэмжээтэй архи согтууруулах ундаа хэрэглэхэд, эрэгтэй хүн 3 буюу түүнээс дээш стандарт хэмжээтэй архи согтууруулах ундаа хэрэглэхэд даралт ихэсдэг. Эмэгтэй хүн 1, эрэгтэй хүн 2 стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй архи согтууруулах ундаа хэрэглэх нь тохиромжтой [16,56]. ("Архины даамжирсан хэрэглээний үе дэх зүрх судасны өвчний ач холбогдол, эрсдэлт хүчин зүйл" сэдвээс үзнэ үү.)

**Эмийн эмчилгээ:** Даралт бууруулах эмийг хэрэглэснээр зүрхний дутагдлын эрсдэл 50%, цус харвалтын эрсдэл 30 – 40%, зүрхний булчингийн шигдээсний эрсдэл 20 – 25% буурдаг. 65 ба түүнээс дээш настай хүмүүст даралт бууруулах эм хэрэглэсэн ДД ихтэй хүмүүст дээрх эрсдэлүүд буурах нь ижил, илүү байдаггүй. 75-аас дээш настай, 10 жилийн зүрх судасны өвчнөөр өвчлөх эрсдэл <10%, нэг дүгээр шатны даралт ихсэлттэй, зүрх судасны илэрхий өвчингүй хүмүүст даралт бууруулах эмийн нөлөө тодорхой бус эргэлзээтэй байдаг.

Эмийн эмчилгээг сонгохдоо хувь хүнд тохирсон, шийдвэр гаргалтад өвчтөнийг оролцуулсан байна. АЗСК, АЗСН-ээс 2017 онд гаргасан удирдамжийн дагуу доорх тохиолдлуудад эмийн эмчилгээ эхлэхийг зөвлөдөг:

- Гэрт хэмжсэн СД  $\geq 135$  ммМУБ эсвэл ДД  $\geq 85$  ммМУБ байгаа эсвэл эмнэлэгт хэмжсэн дундаж СД  $\geq 140$  ммМУБ, ДД  $\geq 90$  ммМУБ байгаа тохиолдолд
- Гэрт хэмжсэн СД  $\geq 130$  ммМУБ эсвэл ДД  $\geq 80$  ммМУБ байгаа эсвэл эмнэлэгт хэмжсэн дундаж СД  $\geq 130$  ммМУБ, ДД  $\geq 80$  ммМУБ бөгөөд зүрх судасны өвчний эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн, хоёрдугаар хэв шинжийн чихрийн шижинтэй, бөөрний архаг өвчтэй, 65 нас ба түүнээс дээш, 10 жилийн зүрх судасны өвчний эрсдэл 10%-аас багагүй зэрэг шинжүүдээс байгаа тохиолдолд
- Гэвч 1 дүгээр шатны АГ-тэй (СД 130 - 139 ммМУБ, ДД 80 - 89 ммМУБ), 75 нас ба түүнээс дээш настай, 10 жилийн зүрх судасны өвчний эрсдэл 10%-аас багагүй, зүрх судасны өвчингүй, чихрийн шижингүй, бөөрний архаг өвчингүй хүнд эмийн эмчилгээний үр дүн, цаашдын эрсдэлийн үр дүн тодорхойгүй. Иймээс ийм хүмүүст

хувь хүнд тохирохуйц эмчилгээг сонгохын тулд өвчтөнийг эмчилгээний шийдвэр гаргалтад оролцуулан сонгох хэрэгтэй. ("Даралт ихсэлттэй насанд хүрэгсдийн цусны даралтын зорилтот хэмжээ" ба "Настайчуудын даралт ихсэлт", сэдвээс үзнэ үү.)

**Эмийн эхний сонголт:** Даралт бууруулах эмийн эмчилгээний зорилго нь зүрх судасны өвчний эрсдэлийг бууруулахад оршино [58,61- 63]. Эмийг сонгохдоо зүрх судасны өвчний эрсдэлийг бууруулах, даралт бууруулах нөлөө, аюулгүй байдал, тэсвэр чанарыг бодолцон шаардлагатай тохиолдолд нэгээс дээш бүлгийн эмийг хувь хүнд тохируулан сонгож хүссэн үр дүндээ хүрнэ. Альдостероны антагонист нь зүрхний 3, 4 дүгээр шатны зүрхний дутагдалтай эсвэл зүрхний булчингийн шигдээсний дараах зүүн ховдлын шахалтын фракцын сулралтай байгаа үед үр дүн сайтай. Хавсарсан өвчний заалтаар тусгайлан эм сонгон хэрэглэх шаардлагатай биш бол АЗСК, АЗСНийгэмлэгээс 2017 онд гаргасан зөвлөмжийн дагуу эмийн эмчилгээг сонгоно [4]. ("Анхдагч даралт ихсэлтийн эмийн сонголт" сэдвээс үзнэ үү.)

- Тиазид төст эсвэл тиазидын шээс хөөх эм
- Уртасгасан үйлдэлтэй кальцийн сувгийн хориглогч (Ихэнхдээ дигидропиридин болох амлодипин)
- Ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч (АХФС)
- Ангиотензин рецепторын хориглогч (АРХ)

Дээрх 4 бүлэг эмийг хэрэглэхэд зүрх судасны өвчний нас баралтын эрсдэл ялгаагүй байдаг [64].

Эмийн эхний сонголтыг хийхэд анхаарах зүйлс:

- Чихрийн шижингийн нефропати, чихрийн шижингийн бус бөөрний архаг өвчтэй, ялангуяа шээсээр уураг алдаж байгаа өвчтөнд АХФС, А2РХ эмүүдээс дангаар нь сонгох хэрэгтэй. ("Чихрийн шижинтэй өвчтөний даралт ихсэлтийн эмчилгээ" ба "Чихрийн бус шижингийн шалтгаант бөөрний архаг өвчний даамжрал болон даралт ихсэлтийн эмчилгээ" сэдвээс үзнэ үү.)
- Зүрхний цус хомсдох өвчин, эсвэл зүрхний шахалтын фракц буурсан зүрхний дутагдалтай хүнд бета хориглогч хэрэглэхийг зөвлөхгүй [65,66]. ("Анхдагч даралт ихсэлийн эмийн эмчилгээний сонголт" сэдвээс үзнэ үү.)

**Хавсарсан эмийн эмчилгээний сонголт:** ДД-ыг бууруулах хэмжээ 15 ммМУБ түүнээс их байгаа тохиолдолд хавсарсан эмийг хэрэглэх нь үр дүнтэй байдаг. 2 өөр бүлгийн эмийг хавсруулан хэрэглэх нь нэг эмийг өндөр тунгаар хэрэглэхээс үр дүн сайтай, гаж нөлөө багатай байдаг. Хавсран хэрэглэх эмийг удаан үйлдэлтэй АХФС эсвэл АРХ –ыг

дигидропиридин кальцийн сувгийн хориглогчтой хэрэглэнэ. АХФС эсвэл АРХ-ыг тиазид шээс хөөх эмтэй хэрэглэж болох ч гидрохлоротиазидтай хэрэглэх нь үр дүн багатай. АХФС болон АРХ –ыг хамтад нь хэрэглэж болохгүй ("Анхдагч даралт ихсэлтийн эмчилгээ" сэдвээс үзнэ үү.)

СД 20 ммМУБ, ДД 10 ммМУБ—аас илүү бууруулах зорилготой тохиолдолд даралт бууруулах 2 өөр бүлгийн эхний эгнээний эмүүдийн хослолыг хэрэглэнэ [4,5]. ('Цусны даралтын бай хэмжээ') сэдвээс үзнэ үү.) Дээрх 2 эмийг хэрэглээд даралт хянагдахгүй байвал АХФС эсвэл АРХ-ын аль нэгийг удаан үйлдэлтэй дигидропиридин кальцийн сувгийн хориглогч болон тиазид төст шээс хөөх эм (хлорталидон илүү тохиромжтой)-тэй хэрэглэнэ. Удаан үйлдэлтэй дигидропиридин кальцийн сувгийн хориглогч нь үр дүнгүй байгаа тохиолдолд дигидропиридин бус кальцийн сувгийн хориглогч (верапамил эсвэл дилтиазем) оронд нь хэрэглэж болно. Хэрэв тиазид төст шээс хөөх эм үр дүнгүй болон эсрэг заалттай байгаа тохиолдолд минералокортикоид рецепторийн антагонист (пиронолактон, эплерон) хэрэглэж болно. Дээрх эмүүд эсрэг заалттай, үр дүнгүй тохиолдолд бета хориглогч, альфа хориглогч, эсвэл шууд артерийн судас тэлэх эмийг хэрэглэж болно. Бета хориглогч, дигидропиридин бус кальцийн сувгийн хориглогчийг хавсруулан хэрэглэхээс зайлсхийнэ. Тун нь өндөр, нэг эм нь шээс хөөх бүлгийн 3 даралт бууруулах эм хэрэглэж байгаа ч даралт хянагдахгүй байгаа тохиолдолд эмд тэсвэртэй артерийн гипертензи гэнэ.

**Артерийн даралтын хяналтын зорилтот хэмжээ:** СД <130 ммМУБ, ДД <80 ммМУБ байх нь АГ-ийн эмчилгээний зорилтот хэмжээ юм. Зарим судлаачид зүрх судасны өвчний эрсдэл бага бол гэрийн хэмжилтэд СД <135 ммМУБ, ДД <85 ммМУБ, эмнэлгийн хэмжилтэд СД <140 ммМУБ, ДД <90 ммМУБ байх тохиромжтой гэдэг [4]. Даралт буулгах эмчилгээ эхэлсний дараа сар тутамд хянаж, эмийн тунг тааруулан зорилтот үр дүндээ хүрэх хэрэгтэй. Нэгэнт хяналтын зорилтот түвшинд хүрсэн тохиолдолд 3-6 сар тутамд хянуулна [4].

**Тэсвэртэй даралт ихсэлт:** Тун нь хангалттай, нэг эм нь шээс хөөх бүлгийн 3 даралт бууруулах эм хэрэглэж байгаа ч даралт хянагдахгүй байгаа тохиолдолд эмд тэсвэртэй АГ гэнэ [68]. Дор хаяж 4 эмийн хослолоор хянагддаг даралтыг хяналттай тэсвэртэй АГ гэнэ. Хуурамч эмд тэсвэртэй даралт ихсэлт нь даралт зөв хэмжээгүй, даралт бууруулах эм зөв хэрэглээгүй, даралт бууруулах амьдралын хэвшил, хоолны дэглэм баримтлаагүй, цагаан халаадны АГ байж болно ("Тэсвэртэй АГ-ийн тодорхойлолт, эрсдэлт хүчин зүйл, үнэлгээ" ба "Тэсвэртэй АГ-ийн эмчилгээ" сэдвээс үзнэ үү.)

**Гипертензийн аюултай байдал:** Хүнд хэлбэрийн АГ (ДД 120 ммМУБ-аас дээш), бай эрхтний гэмтэл цочмоогоор илэрсэн байдлыг АГ-ийн аюултай байдал гэнэ (хүснэгт 11). Уг нөхцөл байдал нь амь насанд аюултай бөгөөд нэн яаралтай эмчилгээ шаардлагатай байдаг ("Насанд хүрэгсдийн АГ-ийн аюултай байдлын үнэлгээ, эмчилгээ" сэдвээс үзнэ үү.) Хүнд хэлбэрийн АГ нь (ДД 120 ммМУБ-аас дээш) эрхтэн тогтолцооны эцсийн шатны эмгэг цочмог байдлаар илрээгүй өвчтөнд даралт ихсэхийг хэлнэ [4]. Даралтыг огцом буулгахад өвчтөнүүдэд үр дүнтэй эсэх нь батлагдаагүй [4,69-71]. Гипертензийн аюултай байдал нь голдуу даралтын эмээ тогтмол хэрэглэдэггүй хүмүүст тохиолддог ("Насанд хүрэгсдийн даралт ихсэлтийн аюултай байдлын үнэлгээ, эмчилгээ" сэдвээс үзнэ үү.)

**Эмчилгээг зогсоох:** Нэгдүгээр шатны даралт ихсэлттэй өвчтөнүүд голдуу 1 эм хэрэглэн, даралтаа сайн хянаж чаддаг. Хэдэн жилээр хэрэглэсний дараа даралт буулгах эмийг зогсоосноор зарим өвчтөнд 1-2 жилээс дээш хугацаанд [72]; хэвийн даралттай байдаг, харин ихэнх өвчтөнд эмийн тоо, тунг бууруулж болно [73,74]. Олон эмээр даралтаа сайн барьдаг өвчтөнд эмийн тунг аажим бууруулж болно. Богино үйлдэлт бета хориглогч пропранолол, альфа 2 агонист болох клонидин зэрэг эмийг огцом хэрэглээг зогсоосноор амь насанд аюултай байдалд хүрч болзошгүй. Тиймээс аажим хэрэглээг бууруулах нь зүйтэй. ("Даралт ихсэлтийн эмийн эмчилгээг зогсоох аюултай хам шинжүүд" сэдвээс үзнэ үү.)

**Цусны даралтын хяналтыг сайжруулах системтэй арга :** Анхаарал, асаргаа сайн байх нь цусны даралтын хяналтыг сайжруулдаг. Доорх багийн ажиллагааны аргуудаас нэг буюу түүнээс дээш аргыг хэрэглэснээр цусны даралтын хяналтыг сайжруулна [4]:

- Цахим болон утсаар баталгаат даралтын аппаратаар хэмжсэн даралтын хэмжээг хяналтын эмнэлэгт дамжуулах
- 24 цагийн даралтын хяналтын аппарат, автомат даралтын аппаратын хүртээмжийг нэмэгдүүлэх
- АГ нь эмээр хянагдахгүй байгаа тохиолдолд асран хамгаалагчид хяналтын эмнэлгийн ажилтнуудтай байнгын холбоотой байх
- Эм зүйчийг эмчилгээний багт оруулах
- Эмийн тунг тогтоох шаталсан алгоритм хэрэглэх
- Хянахад хүндрэлтэй АГ-тэй өвчтөнийг эмнэлзүйн даралт ихсэлтийн нарийн мэргэжилтэнтэй холбогдох боломжийг нэмэгдүүлэх
- Тэсвэртэй даралт ихсэлт болон муу хяналттай даралт ихсэлтийн шалтгаанд эмчилгээний багтай холбоо муу байх ордог ("АГ-ийн эмчилгээ болон өвчтөний байнгын холбоо" сэдвээс үзнэ үү.)

## УДИРДАМЖУУД

Тодорхой улс болон бүсүүдийн нийгэмлэгийн зүгээс гаргасан удирдамжуудыг тусад нь оруулсан болно. ("Нийгэмлэгийн удирдамжууд: Насанд хүрэгчдийн даралт ихсэлт" сэдвийг үзнэ үү.)

## ДҮГНЭЛТ БОЛОН ЗӨВЛӨМЖҮҮД

### АГ-ийн тодорхойлолт

Америкийн Зүрх Судасны Коллеж, Америкийн Зүрх Судасны Нийгэмлэгээс 2017 онд гаргасан доорх тодорхойлолт, шатлал (хүснэгт 1)-ыг ашиглана ('Тодорхойлолт' дээд талаас үзнэ үү.):

- Хэвийн – СД <120 ммМУБ, ДД <80 ммМУБ
- Даралт ихсэлт – СД 120 - 129 ммМУБ, ДД <80 ммМУБ
- Артерийн гипертензи:
  - Артерийн гипертензийн 1-р зэрэг – СД 130 - 139 ммМУБ эсвэл ДД 80 - 89 ммМУБ
  - Артерийн гипертензийн 2-р зэрэг – СД дор хаяж 140 ммМУБ эсвэл ДД 90 ммМУБ

Үе шатаар нь ангилахдаа эргэлзээтэй байвал аль өндөр шатаар нь үнэлнэ. Даралт ихсэлтийг оношлоход гэрийн болон эмнэлэгт хэмжсэн даралтыг хавсруулан, шаардлагатай бол 24 цагийн турш хянана (хүснэгт 3). 24 цагийн турш даралтыг хянахад дараах шалгууруудаас 1-ээс дээш илэрч байвал онош тавина. ('Эмнэлгийн болон гэрийн даралт ихсэлтийг үнэлэх тодорхойлолт' дээд талаас үзнэ үү.):

- 24 цагийн дундаж СД  $\geq 125$  ммМУБ эсвэл ДД  $\geq 75$  ммМУБ
- Өдрийн дундаж СД  $\geq 130$  ммМУБ эсвэл ДД  $\geq 80$  ммМУБ (Хамгийн тохиромжтой оношилгооны шалгуур)
- Шөнийн дундаж СД  $\geq 110$  ммМУБ эсвэл ДД  $\geq 65$  ммМУБ

### Даралт хэмжилт

- Зөв техникээр даралт хэмжиж дүгнэх нь оношилгоо эмчилгээний чухал хэсэг ('Цусны даралтын хэмжилт' дээд хэсгээс үзнэ үү):
- Чагнууртай даралтын аппаратаас илүү осцилметрик даралтын аппаратыг эмнэлэгт хэрэглэхийг зөвлөнө. Автомат даралтын аппаратаар эмнэлэгт хэд хэдэн хэмжилтийг өвчтөнийг сууж амарч байх үед, эмнэлгийн мэргэжилтний хяналттай, болон хяналтгүй хийж болно. Автомат даралтын аппарат нь өдрийн цагаар даралтыг



цагаан халаадны нөлөөгүй, илүү бодитой хэмжинэ ('Эмнэлэгт даралт хэмжих нь' дээд хэсгээс үзнэ үү)

- 24 цагийн даралтын хяналт нь даралт ихсэлтийн оношийг тогтоох гол арга юм. 24 цагийн даралтын монитороор бай эрхтний гэмтэл, зүрх судасны эрсдэлт тохиолдлыг таамаглах боломжтой ("Эмнэлгээс гадна даралт хэмжих нь: Эмнэлэгт болон өөрөө хэмжиж даралтаа хянах нь" сэдвээс үзнэ үү).
- Өвчтөн гэртээ даралтаа хэмжихдээ аль болох автомат, баталгаатай аппаратыг ашиглан бугалгадаа манжетаа байрлуулан, чимээгүй өрөөнд 5 минутаас дээш хөлөө зөрүүлэлгүй, нуруу, тохойдоо тулгууртай сууж хэмжилт хийнэ. Сард нэг долоо хоногийн турш өглөө, оройд хэмжин дор хаяж 12-14 удаагийн хэмжилт хийнэ. ('Гэрт даралт хянах' дээд хэсгээс үзнэ үү.)

### Артерийн гипертензийн оношилгоо

Дараах тохиолдлуудад нэмэлт хэмжилт хийхгүйгээр онош тавьж болно.

- СД  $\geq 180$  ммМУБ эсвэл ДД  $\geq 120$  ммМУБ хүрэх
- СД  $\geq 160$  ммМУБ эсвэл ДД  $\geq 100$  ммМУБ бөгөөд зүрхний зүүн ховдлын томрол, нүдний торлогийн гэмтэл, зүрх судасны цус хомсдох зэрэг өвчтэй

Бусад тохиолдолд эмнэлэгт хэмжсэн даралтаар, гэрт хэмжсэн даралтыг баталгаажуулан шалгаж оношийг тавина. 24 цагийн даралт хэмжилт нь "алтан стандарт" боловч цагаан халаадны даралт ихсэлтийг үгүйсгэхийн тулд гэрт хэмжсэн даралтыг ашиглах хэрэгтэй болдог тул ихэнх өвчтөнд гэрт хэмжсэн даралтад үндэслэн оношилно.

- Гэрт хэмжсэн даралт эмнэлэгт хэмжсэн даралттай таарч СД  $\geq 130$  ммМУБ эсвэл ДД  $\geq 80$  ммМУБ байгаа тохиолдолд АГ гэж оношилно
- Гэрт хэмжсэн даралт, эмнэлэгт хэмжсэн даралттай зөрүү ихтэй байгаа тохиолдолд 24 цагийн монитороор хянаж өдрийн дундаж СД  $\geq 130$  ммМУБ эсвэл ДД  $\geq 80$  ммМУБ байгаа тохиолдолд АГ гэж оношилно.

Гэртээ даралтаа хэмжих боломжгүй өвчтөнд эмнэлэгт дор хаяж 3 удаа долоо хоногоос сарын зайтай ирж даралтаа хэмжүүлэн дундаж СД  $\geq 130$  ммМУБ эсвэл ДД  $\geq 80$  ммМУБ

### Үнэлгээ

Даралт ихсэлт гэрийн болон эмнэлгийн хэмжилтээр батлагдсан тохиолдолд дараах нөхцөл байдлуудыг үнэлнэ ("[Насанд хүрэгсдийн даралт ихсэлтийн эхний үнэлгээ](#) сэдвээс үзнэ үү.):

- Бай эрхтний гэмтэл
- Бөөр, зүрх судасны өвчтэй

- Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлтэй, эсвэл эрсдэлгүй ("Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлийн тойм" сэдвээс харна уу.):
